ӨСВӨР ҮЕИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ч.АДЪЯАСҮРЭНГИЙН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин<br>Эхний хагас жил | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| НЭГ. **“Иргэд, гэр бүл, байгууллага, хамт олны эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх үйл ажиллагаануудыг зохион байгуулж, эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлүүдийг бууруулах” зорилтын хүрээнд** | | | | | |
| 1 | **Арга хэмжээ № 1.1.** Өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх | -Тусламж үйлчилгээ авсан хүүхдийн тоо<br>-Зөвлөгөө авсан хүүхдийн тоо | -Биечлэн зөвлөгөө авсан хүүхдийн тоо - 130<br>-Утсаар зөвлөгөө авсан хүүхдийн тоо - 90 | - Биечлэн зөвлөгөө авсан хүүхдийн тоо – 80<br>- Утсаар зөвлөгөө авсан хүүхдийн тоо - 50 | Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Сумын эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Хүүхэд өсвөр үеийнхнийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг Ерөнхий боловсролын сургуультай хамтран зохион байгуулж байна.. Үүнд:<br><br>1.Нэгдсэн эмнэлэг, Сумын эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 2025 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн Эрүүл мэндийн газрын даргын 05 тоот албан бичигт Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 504 тоот тушаалыг хавсралтаар хүргүүлэн өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэл өгөн ажилласан.<br><br>2.Ирээдүйн босго ӨҮЭМТ-өөс өсвөр үеийнхний эрүүл мэндийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх 26 удаагийн сургалт, 2 удаагийн нөлөөллийн үйл ажиллагаанд 2800 гаруй өсвөр насныхан хамрагдсан байна.<br><br>3.Цагдаагийн байгууллагатай хамтран “Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг Архангай политехникийн коллеж, 2-р сургууль,3-р сургууль, 5-р сургуулийн ахлах ангийн 260 гаруй охидод хийж мэдлэгийн сайжруулсан. Сургалтад хамрагдсан охидод гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн халдлагын талаарх ойлголтыг өгч, түүнээс урьдчилан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | сэргийлэх, бие мах бодид үүсэх шинж тэмдэг, сэтгэлд зүйд илрэх шинж тэмдэг, хүчирхийлэлд өртсөн үед хаана хандах зэрэг мэдээлэлийг өгсөн. Мөн сургалтанд суусан хүүхдүүдэд гэр бүлийн хүчирхийллийн илрэх шинжүүд, найз чинь хүчирхийлэлд өртсөн эсэхийг хэрхэн таних, хүчирхийллээс ангижрах алхамууд, найздаа хэрхэн тусалж чадах вэ зэрэг 2 төрлийн 100 гаруй гарын авлага тараасан. |
| 2 | **Арга хэмжээ №1.2. "** Өсвөр үеийн зөвлөл "-ийн гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах | -Сургалтын удирдамж<br>-Хийсэн ажлын тайлан | - | - НЭ, Өрх, Сумын ЭМТ-дэд сургалтын удирдамж хүргүүлэх | Чулуут сумын өсвөр үеийн зөвлөлийн 15 гишүүнийг чадавхижуулах сургалтанд хамруулан өсвөр насны хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл зүйн онцлог, өсвөр насны хүүхдийн хувийн эрүүл ахуй, амны хөндийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн сайжруулсан. |
| 3 | **Арга хэмжээ №1.3**. "Өсвөр нас - Эрүүл мэнд" сургалтыг ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад зохион байгуулах | -Сургалтын хөтөлбөр<br>-Хамрагдсан хүүхдийн тоо | -Сургалтын тоо – 5<br>-Хамрагдсан ахлах ангийн сурагч - 150 | - Сургалтын тоо – 4<br>- Хамрагдсан ахлах ангийн сурагч – 140 | "Өсвөр нас - Эрүүл мэнд" сургалтыг Эрдэнэ-Булган сумын 2,3,5-р сургууль, Тариат сумын ахлах ангийн сурагчдад эрүүл мэндийн мэдлэг олгох сургалтыг 6 удаа зохион байгуулж, 300 хүүхдийг хамруулсан байна. |
| 4 | **Арга хэмжээ №1.4**. "Өсвөр үеийн дэлхийн -7 хоног" нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах | -Үйл ажиллагааны удирдамж | - Сургалтын тоо – 15<br>-Хамрагдсан ахлах ангийн сурагч - 2000 | -Сургалтын тоо – 20<br>-Хамрагдсан ахлах ангийн сурагч - 1000 | Өсвөр насныханд тулгамдаж буй эрүүл мэндийн өвөрмөц асуудлуудын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, анхаарлыг хандуулах, өсвөр үеийнхний эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, олон нийт болон өсвөр үеийнхний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 4 дүгээр сарын 15-аас эхлүүлж буй "ӨСВӨР ҮЕИЙНХНИЙГ СОНСЪЁ, ОЙЛГОЁ" нэг сарын арга хэмжээнд ЭМГ, НЭ, Сум, Өрхийн эрүүл мэндийн төвүүд нэгдэн өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа мэдээлэл, зөвлөгөөг удирдамжийн дагуу өгч ажилласан. Сарын аяны хүрээнд 4500 иргэнд байгууллагын цахим хаягаар мэдээлэл өгч, гэр бүлийн хүчирхийлэл, үе тэнгийнхний |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | дарамт, бэлгийн хүчирхийлэл, архи, тамхи эрүүл мэндэд нөлөөлөх талаарх мэдлэг дадалыг өөрчлөх сургалт , сурталчилгаа мэдээллийг хийсэн байна. |
| 5 | **Арга хэмжээ №1.5**. "Өсвөр насны нөхөн үржихүйн эрүүл мэнд" сургалтыг ЕБС-ийн ахлах, дунд ангийн сурагчдад зохион байгуулах | -Сургалтын хөтөлбөр<br>-Хамрагдсан хүүхдийн тоо | -Сургалтын тоо – 8<br>-Хамрагдсан ахлах ангийн сурагч - 500 | -Сургалтын тоо – 5<br>-Хамрагдсан ахлах ангийн сурагч - 260 | Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд тогтмол хийж мэдээлэлээр хангаж байна.<br>Ирээдүйн босго ӨҮЭМ-ийн төвөөс Эрдэнэбулган сумын 2-р сургууль, 5-р сургууль, Чулуут сумын ахлах ангийн сурагчдад "Өсвөр нас – Эрүүл мэнд", "Нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Охидын эрүүл ахуй", " Гэр бүл төлөвлөлт" сэдвээр 4 удаагийн сургалт зохион байгуулсан. Сургалтанд 260 гаруй хүүхэд хамрагдаж мэдлэгээ сайжруулсан.<br>Архангай Политехникийн коллежийн 45 оюутанд "НҮЭМ", "Гэр бүл төлөвлөлт", "БЗДХ" сэдвээр сургалт хийж мэдлэгийн сайжруулсан.<br>МУБИС-ийн харъяа Багшийн сургуулийн хүсэлтээр оюутнуудад эрүүл мэндийн боловсрол олгох 3 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 250 оюутан хамрагдсан байна |
| 6 | **Арга хэмжээ №1.6**. "Өсвөр нас- сэтгэцийн эрүүл мэнд" сургалтыг ЕБС-ийн сурагчдад зохион байгуулах | -Сургалтын хөтөлбөр | - Сургалтын тоо – 4<br>Хамрагдсан ахлах ангийн сурагч - 200 | -Сургалтын тоо – 3<br>-Хамрагдсан ахлах ангийн сурагч - 100 | "ӨСВӨР ҮЕИЙНХНИЙГ СОНСЪЁ, ОЙЛГОЁ" нэг сарын аяны хүрээнд ЭБ сумын 1-5-р сургуулийн сурагчдад "Өсвөр насны сэтгэл зүй" сэдвээр сургалт хийж мэдлэгийн сайжруулсан. 5 удаагийн сургалтанд 300 хүүхдийг хамруулсан.<br>Мөн Сум, Өрхийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн НЭМ-ийн ажилтанууд аяны хүрээнд сэтгэцийн эрүүл мэндийн талаар хүүхэд өсвөр үе залуучууд иргэдэд мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. |
| 7 | **Арга хэмжээ №1.7**. Өсвөр үе, залуучуудын осол гэмтлийн шалтгаанд сүүлийн 3 жилийн /2021-2023 он/ байдлаар дүгнэлт хийж, зөвлөмж гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэх, олон нийтэд мэдээлэх | -Өсвөр үе, залуучуудын осол гэмтлийн шалтгаанд дүгнэлт хийх | НЭ, Сум , Өрхийн ЭМТ- дэд зөвлөмж хүргэх | Өсвөр үе, залуучуудын осол гэмтлийн шалтгаанд дүгнэлт хийж НЭ, Сум , Өрхийн ЭМТ- дэд зөвлөмж | Өсвөр үе, залуучуудын осол гэмтлийн шалтгаанд дүгнэлт хийж НЭ, Сум, Өрхийн ЭМТ-ийн эмч мэргэжилтэн нар болон иргэдэд сургалт хийхдээ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хүргэх | мэдээлэл өгч байна. |
| 8 | **Арга хэмжээ № 1.8.** Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг дэмжих сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах | -Сургалтын хөтөлбөр боловсруулан Сум, Өрхийн ЭМТ-д хүргүүлэх<br>-Ажлын хэсгийн тайлан | - | Ажлын хэсэг хуваарийн дагуу сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулна. | АШУҮИС-ийн Нүүр ам судлалын сургуулийн багш нар амны хөндийн эрүүл ахуй, шүд цоорлоос урьдчилан сэргийлэх, шүд угаах арга зүй ,бага насны хүүхдийн шүд угаах дараалал, хэрэглэгдэхүүний талаар сургалт хийж цэцэрлэг, сургуулийн эмч нарын амны хөндийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн сайжруулсан.<br>Сургалтанд 45 цэцэрлэг, сургуулийн эмч нар хамрагдсан.<br><br>Шүдний кабинеттай 17 сумын ЭМТ, хувийн хэвшлийн 4 шүдний ЭМБ, Нэгдсэн эмнэлгийн нийт 17 эмч, сувилагч нар шүдний урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээ оношилгооны талаар сургалтанд сууж мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна<br><br>24/3 ШҮДЭЭ ЗӨВ УГАА аяны хүрээнд хүн бүр өдөрт шүдээ 3 удаа,3 минутын турш шүдээ зөв угаах дадал хэвшил эзэмшүүлэх, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд рүү чиглэсэн үйл ажиллагааг Эрүүл мэндийн байгууллагууд урьдчилан сэргийлэх үзлэг болон сургалтыг зохион байгууллаа.<br>Аяны хүрээнд:<br>- 80 удаагийн сургалтанд 5000 хүн хамрагдаж шүд угаах арга аргачлалд суралцсан байна.<br>- Урьдчилан сэргийлэх үзлэгт 2139 хүүхэд хамрагдсанаас, 950 хүүхэд шүдний цоорлоос сэргийлж фтор түрхүүлж, 536 хүүхэд шүдний эмчилгээнд хамрагдаж эрүүлжсэн байна.<br>- 340 жирэмсэн эх сургалтанд хамрагдаж амны хөндийн эрүүл мэндийн талаарх мэдлэгээ сайжруулсан байна<br>- 24/3 ШҮДЭЭ ЗӨВ УГАА аяны хүрээнд Чулуут сум "Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж шүд угаалтын аваргуудаа шалгаруулан урамшуулсан<br>Сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгт ерөнхий |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн 1770 хүүхдийг шүдний эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан цоорлоос сэргийлэх түрхлэг түрхэн, эмчлэх эрүүлжүүлэх ажил үргэлжлэн зохион байгуулагдаж байна.<br>Шүдний эрт илрүүлэг үзлэгт 2025 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар нийт 1764 суралцагч хамрагдахаас 1728 буюу 98.0 хувь нь үзлэгтээ хамрагдаж үүнээс 1155 буюу 73.06 хувь нь шүдний эмгэгтэй илэрсэн байна.Үүнээс:<br>• Шүдний цооролттой хүүхдийн тоо1 – 434<br>• Шүдний гажигтай хүүхдийн тоо4- 27<br>• Шүдээ бүрэн угаадаггүй хүүхдийн тоо-1421<br>• 1270 буюу 71 хувь нь эмчлүүлээд байна<br>• Мөн эцэг эх асран хамгаалагч нарт амны хөндийн эрүүл ахуйн талаар, шүдээ зөв угаах талаар зөвлөгөө мэдээлэл өгч байна.<br><br>Мөн эцэг эх асран хамгаалагч нарт амны хөндийн эрүүл ахуйн талаар, шүдээ зөв угаах талаар зөвлөгөө мэдээлэл өгч байна. |
| 9 | **Арга хэмжээ № 1.9**. "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд" өдөрлөг зохион байгуулах | -Өдөрлөгийн удирдамж боловсруулан СЭМТ-д хүргүүлэх | 4 суманд зохион байгуулсан. | 2 суманд зохион байгуулна. | Санхүүжилт байхгүй |
| 10 | **Арга хэмжээ № 1.10**. Өсвөр насны хүүхдийн өвчлөл, эндэгдэл, жирэмслэлт, төрөлт, эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар дүгнэлт хийж, сум, өрхийн ЭМТ-дэд зөвлөмж хүргүүлэх | -Сум, Өрхийн ЭМТ-дэд зөвлөмж хүргүүлэх | | Өсвөр насны хүүхдийн өвчлөл, эндэгдэл, жирэмслэлт, төрөлт, эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар дүгнэлт хийж, сум, өрхийн ЭМТ-дэд зөвлөмж хүргүүлэх | Өсвөр насны хүүхдийн өвчлөл, эндэгдэл, жирэмслэлт, төрөлт, эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар дүгнэлт хийж НЭ, Сум , Өрхийн ЭМТ-ийн эмч мэргэжилтэн нарыг мэдээлэлээр хангасан.<br><br>Мөн Хүүхдийг хууль зүйн хорооны гишүүдэд мэдээлэл өгч өсвөр насны охидын жирэмслэлт, төрөлт, үр хөндөлтийн тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг хийсэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11 | **Арга хэмжээ № 1.11**. ЕБС-ийн дотуур байрны орчинд хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд үнэлгээ хийж, зөвлөмжөөр хангах | -Үнэлгээ хийгдсэн дотуур байрны тоо | Сумын ЕБС-ийн дотуур байр - 4<br>ЭБ сумын ЕБС-ийн дотуур байр - 2 | Сумын ЕБС-ийн дотуур байр - 3<br>ЭБ сумын ЕБС-ийн дотуур байр – 1<br>Архангай МСҮТ-ийн дотуур байр - 1 | ЭБ сумын 5-р сургууль болон Чулуут сумын сургуулийн дотуур байранд дэмжлэгт хяналт хийж хүүхдийн эрүүл мэндийг дэмжих хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай танилцан арга зүйн зөвлөгөө өгөн ажилласан.<br>Дотуур байрны багш, сургуулийн эмч, тогооч, байрны үйлчлэгч нарт чиглэл чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.<br>2025 онд Хүүхдийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч 7 сургууль, 7 цэцэрлэгт хоолны чанар, хүртээмжид үнэлгээ хийж холбогдох удирдлага нярав тогооч эмч нарт сургалт зохион байгуулан зөвлөмж хүргүүлсэн |
| 12 | **Арга хэмжээ № 1.12.** ЕБС-ийн дунд, ахлах ангийн багш нарт "Өсвөр нас – Эрүүл мэнд" сургалт зохион байгуулах | -Сургалтын тоо<br>-Хамрагдсан багш нарын тоо | Сургалтын тоо 3<br>Хамрагдсан багш нарын тоо<br>40 | - Сургалтын тоо -2<br>-Хамрагдсан багш нарын тоо -25 | ЭБ сумын 2-3 сургууль, Чулуут сумын сургуулийн эрүүл мэндийн хичээлийн багш, дотуур байрны багш, нийгмийн ажилтан, дунд ахлах анги удирдсан багш нар "Өсвөр нас эрүүл мэнд" сургалтанд хамрагдсан. Тус 3 удаагийн сургалтанд 20 гаруй багш, сургуулийн эмч нийгмийн ажилтан нар хамрагдаж мэдлэгээ сайжруулсан. |
| 13 | **Арга хэмжээ№ 1.13.** Үе тэнгийн сургагч бэлтгэх | -Сургалтын тоо<br>-Хамрагдсан сургагч багшийн тоо | Сургалтын тоо- 2<br>Хамрагдсан сургагч багшийн тоо 50 | Сургалтын тоо- 2<br>Хамрагдсан сургагч багшийн тоо - 40 | Чулуут сумын "Өсвөр үеийн зөвлөл"-ийн 15 хүүхдийг чадавхижуулах сургалтанд хамруулан мэдлэгийн сайжруулсан |
| 14 | **Арга хэмжээ №1.14.** Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаануудыг зохион байгуулах | -Сургалтын тоо<br>-Хамрагдсан иргэдийн тоо<br>-Тайлан | - Сургалтын тоо – 4<br>Хамрагдсан ахлах ангийн сурагч - 200 | -Сургалтын тоо – 3<br>-Хамрагдсан иргэдийн тоо - 200 | МУБИС-ийн харъяа Багшийн сургуулийн 38 тоот албан бичгийн дагуу оюутан суралцагч нарт Насан туршийн боловсролийн төвтэй хамтран 2 удаагийн сургалтаар 250 гаруй оюутанд эрүүл мэнд ялангуяа Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, |
| 15 | **Арга хэмжээ № 1.15** Оюутан, суралцагчдын эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх судалгаа хийх | -Судалгааны асуумж<br>-Судалгааны дүгнэлт | - | -Судалгаанд хамрагдсан оюутны тоо 150<br>-Судалгааны дүгнэлт | Хугацаа болоогүй. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **ХОЁР. Эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээг сайжруулах ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд:** | | | | | |
| 16 | **Арга хэмжээ № 2.1**. 0-17 насны хүүхдүүдийг эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах үйл ажиллагаар эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан | 0-17 насны хүүхдийн 80 хувь нь эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан. | Зааврын дагуу үзлэгийг зохион байгуулж байгаа байдалд 2 өрхийн ЭМТ-д хяналт хийж, зөвлөмж өгсөн байна | Эрт илрүүлэг үзлэгт аймгийн хэмжээнд **38447** явуулын үзлэгээр 9323 нийт **47770** хүн хамрагдсан нь нийт хамрагдвал зохих хүн амын **51.2** хувийг эзэлж байна.Үзлэгт хамрагдсан иргэдийн **18384** буюу **48** хувь нь эрэгтэйчүүд, **20063** буюу **52.1** хувь нь эмэгтэйчүүд байна.<br>Үзлэгт хамрагдсан нийт хүний 25751 буюу 70. хувь нь 0-17 насны хүүхэд, 12696 буюу 33 хувь нь 18-аас дээш насныхан байна. |
| 17 | **Арга хэмжээ № 2.2**. ЭБ сумын 18-30 насны залуучуудыг ЭМС-ын 2022 оны А/139 дүгээр тушаалын дагуу эрт илрүүлэг үзлэгт хамралтыг эрчимжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах | Хэрэгжүүлсэн ажлын тайлан | 18-30 насныхны хувь үзлэгт хамрагдсан | Залуучууд олон ажилладаг төрийн болон хувийн хэвшлийн 3 байгууллагад очиж сурталчилгаа хийсэн байна. | |
| 18 | **Арга хэмжээ№2.3** “Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян” зохион байгуулах | Хэрэгжүүлсэн ажлын тайлан | Оюутаны 30 хувь үзлэгт хамрагдсан. | | Хугацаа болоогүй. |
| **Гурав. “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:** | | | | | |
| 19 | **Арга хэмжээ №3.1**. Өсвөр насны хөвгүүдийн тулгамдсан асуудлыг сонсох, хувь хүний нууцлалыг хадгалах, хамтран ярилцах, зөвлөгөө өгөх цахим хуудас ажиллуулах, тогтмолжуулах | Цахим хуудсыг нээж, тогтмол ажиллуулсан тайлан | | Цахим хуудсыг тогтмол ажиллуулсан тайлан | - |
| 20 | **Арга хэмжээ №3.2.** Эрэгтэйчүүд олноор ажилладаг байгууллагын ажилтнуудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт хийх | Сургалтын тоо хамрагдсан хүний тоо | 5 байгууллагад сургалт зохион байгуулсан | 3 байгууллагад сургалт зохион байгуулах | Архангай политехникийн коллежийн суралцагч нарт нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт зохион байгуулсан. Сургалтанд 30 хөвгүүд хамрагдсан. |
| 21 | **Арга хэмжээ №3.3.** Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл, жирэмслэлтээс сэргийлэх байнгын арга болох эрэгтэйн үрийн суваг боох мэс ажилбарын талаар | Хийсэн цахим мэдээллийн төрөл | 2 удаа сургалт зохион байгуулсан | 2 удаа сургалт зохион байгуулах | Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл, жирэмслэлтээс сэргийлэх байнгын арга болох эрэгтэйн үрийн суваг боох мэс ажилбарын талаар таниулах/вазэктоми/, бэлгэвчийн хэрэглээг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | таниулах/вазэктоми/, бэлгэвчийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр жендэрийн мэдрэмжтэй цахим сурталчилгаа хийх | | | | нэмэгдүүлэх чиглэлээр 5 удаагийн сургалтанд 260 хүүхэд хамрагдсан.<br>Мөн байгууллагын цахим хаягаар мэдээлэл сурталчилгаа явагдаж байна. |
| 22 | **Арга хэмжээ №3.4**. Анхан шатны ЭМБ-уудын эмч нарт эрэгтэйчүүд, хөвгүүдэд зориулсан зөвлөгөө өгөх ур чадварын сургалт цахимаар зохион байгуулах | Цахим сургалтад хамрагдсан АШЭМБ-ын тоо | 5 суманд зохион байгуулсан. | 19 сум | Хугацаа болоогүй |
| 23 | **Арга хэмжээ №3.5.** Сургуулийн эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарт хөвгүүдэд зөвлөгөө өгөх ур чадварт сургах цахим сургалт зохион байгуулах | Бэлтгэсэн сургалтын хичээл, Сургалтад хамрагдсан сургуулийн тоо | - | - | Аймгийн ерөнхий боловсролын 30 сургуулийн нийт 37 эмч, багш, нийгмийн ажилтнуудад "Өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэнд", "Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэг" сэдвээр мэдлэг олгох сургалтыг Нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн эмчтэй хамтран зохион байгуулсан.<br>Анхан шатны ЭМБ-дын нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн холбоотой хамтран зохион байгуулсан.Сургалтанд НЭ, Сум, Өрхийн 20 гаруй НЭМ-ийн ажилтнууд хамрагдаж сэтгэцийн эрүүл мэнд нийтийн эрүүл мэнд болох нь, өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэнд, ухуулга, нөлөөлөл сурталчилгаа, үр дүнтэй арга замууд гэх мэт сэдвүүдээр орж мэдлэг ур чадвараа дээшлүүлэн, зөвлөгөө зөвлөмж өгөх арга барилд суралцсан. |
| 24 | **Арга хэмжээ №3.6** Цэргийн ангийн алба хаагчид, цэргүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургал зохион байгуулах | Бэлтгэсэн сургалтын хичээл, Сургалтад хамрагдсан алба хаагчийн тоо | - | Сургалт хийх | Сургалт төвлөгдсөн болович хойшлогдсон. |

<table>
<tr><td>25</td><td>Арга хэмжээ №3.7. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзүүлэлт, нас баралтын шалтгаанд /2021-2023 он/ дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага болон олон нийтэд мэдээллэх</td><td>Хийсэн дүн шинжилгээний тайлан, холбогдох байгууллага, олон нийтэд мэдээлсэн мэдээлэл</td><td>-</td><td>Дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага, олон нийтэд мэдээлсэн байна</td><td>Хүн амын нас хүйс эрүүл мэндийн эрсдэлд суурилсан халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг шинжилгээ оношилгоонд Архангай аймагт 2022 оны 05-р сарын 01-ний өдрөөс 2025 оны 04-р сарын 30-ны өдрийн байдлаар эрт илрүүлэг үзлэгт аймгийн хэмжээнд 38447 явуулын үзлэгээр 9323 нийт 47770 хүн хамрагдсан нь нийт хамрагдвал зохих хүн амын 51.2 хувийг эзэлж байна.Үзлэгт хамрагдсан иргэдийн 18384 буюу 48 хувь нь эрэгтэйчүүд, 20063 буюу 52.1 хувь нь эмэгтэйчүүд байна.<br>Улсын хэмжээнд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү 9,2 байна.<br>Архангай аймгийн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү 3,09 байна.<br>Архангай аймгийн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн дундаж наслалт сүүлийн 5 жилээр
<table>
<tr><td>№</td><td>Үзүүлэлт</td><td>2020</td><td>2021</td><td>2022</td><td>2023</td><td>2024</td></tr>
<tr><td>1</td><td>Нийт</td><td>72.08</td><td>72.27</td><td>72.9</td><td>73,33</td><td>73,22</td></tr>
<tr><td>2</td><td>Эрэгтэй</td><td>69.49</td><td>69.64</td><td>70.57</td><td>71,16</td><td>71,09</td></tr>
</table></td></tr>
<tr><td colspan="6">Дөрөв. “Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгаалал” арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд</td></tr>
<tr><td>26</td><td>Арга хэмжээ №4.1. Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгаалал” чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган батлуулах</td><td>Төлөвлөгөө гарган батлуулах</td><td>-</td><td>Арга хэмжээний төлөвлөгөө гарган батлуулан НЭ, СЭМТ, ӨЭМТ-дэд хүргүүлсэн байна.</td><td>Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн мэдээлэллийг хамтарсан багт шуурхай мэдээлэх, ЭМС-ын А/151 дүгээр тушаал, А/394 дүгээр тушаал, А/364 дүгээр тушаал, А/399 дугаар тушаал, А/97 дугаар тушаалийг багцлан НЭ, сум, өрхийн ЭМТ, ХХЭ–ийн эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах чиглэл өгч ажилласан.<br>Хүүхэд гэр бүл хөгжлийн газартай хамтран хүмүүжлийн албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүдэд эрүүл мэндийн мэдлэг олгох сургалтыг үе шаттай зохион байгуулж байна.<br><br>“Эрүүл мэнд-Зохистой хооллолт”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Сэтгэцийн эрүүл мэнд” зэрэг сэдвийн</td></tr>
</table>

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрээнд мэдээлэл өгч мэдлэгийн сайжруулсан.<br><br>Сургалтанд хамрагдсан 8 хүүхдийн өндөр жинг хэмжиж, Биеийн жингийн индексийг гаргахад 12,5 хувь нь туранхай, 12,5 хувь нь илүүдэл жинтэй, 75 хувь нь хэвийн жинтэй байна. Туранхай, илүүдэл жинтэй хүүхдүүдэд хооллолт болон өөртөө тохирсон дасгал хөдөлгөөн зөв хооллолтын зөвлөгөө мэдээлэл өгсөн. |
| 30 | **Арга хэмжээ №4.2.** Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллаар ЭМС-ын ажилчдад сургалт зохион байгуулах | Сургалтын удирдамж: Хамрагдсан хүний тоо | - | 1 удаа сургалт хийж 30 хүн хамруулсан байна. | ГБХХГ нь хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах сургалт зохион байгуулж сум өрхийн эрүүл мэндийн төвийн эмч сувилагч нар хамрагдаж хүүхдийн хамгааллын чиглэлээр мэдлэгээ сайжруулсан байна. Сургалтанд хамтарсан багийн 23 гишүүн хамрагдсан байна. |
| **Тав. “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд** | | | | | |
| 31 | **Арга хэмжээ №5.1**. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний арга хэмжээний төлөвлөгөө гарган батлуулах | Төлөвлөгөө гарган батлуулах | - | Арга хэмжээний төлөвлөгөө гарган батлуулан НЭ, СЭМТ, ӨЭМТ-дэд хүргүүлсэн байна. | Төлөвлөгөө гарган сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн. |
| 32 | **Арга хэмжээ №5.2.** . Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх чиглэлээр ЭМС-ын ажилчдад сургалт зохион байгуулах | Сургалтын удирдамж: Хамрагдсан хүний тоо | | 1 удаа сургалт хийж 30 хүн хамруулсан байна. | Хүний эрхийн комиссын Архангай дахь салбар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв хамтран Хотонт, Хашаат сумын ЭМТ-ийн эмч мэргэжилтнүүдэд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргаа Хүний эрх, жендерт суурилсан хүчирхийлээс урьдчилан сэргийлэх нь сэдэвт сургалт хийсэн. Сургалтанд 25 хүн хамрагдсан. |

ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Хүрэх түвшин | Хэрэгжүүлэх ажил | Суурь түвшин | Биелэлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас | | |
| 1 | Өсвөр үеийн тусламж үйлчилгээний талаар сургалтанд хамрагдаж мэдлэгээ | Өсвөр үеийн тусламж үйлчилгээний талаар | Өсвөр үеийн тусламж | 3 удаа сургалтанд хамрагдах | УБ хотод Байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын сургалтанд хувиараа сууж мэдлэгээ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | сайжруулах | сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн байна. | үйлчилгээний чиглэлээр зохион байгуулагдаж байгаа сургалтад оролцох | | сайжруулсан. |
| 2 | Монгол хэл бичгийн хичээлд суун мэдлэгээ сайжруулах | Монгол бичгээр бичиж уншиж сурч мэдлэгээ сайжруулсан байна. | Сургалтанд суух | Анхан шатны сургалтанд суух | Анхан шатны сургалтанд суух, мөн хувиараа монгол бичгээ сурч мэдлэгээ сайжруулж байна. |
| 3 | Эрүүл мэндийн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр сургалтанд сууж мэдлэгээ сайжруулах | ЭМС-т жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр сургалтад хамрагдаж, мэдлэгээ сайжруулсан байна. | Жендерийн эрх тэгш байдлын чиглэлээр сургалтад оролцох | Хууль , эрх зүйн орчинг судлах, мэдлэгээ сайжруулах | Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх 1 өдрийн сургалтанд сууж мэдлэгээ сайжруулсан. |
| 4 | Хүүхдийн эрх, иргэдийн эрүүл мэндээ хамгаалах эрх, үүрэг болон хүүхдийн хамгаалал, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтанд сууж мэдлэгээ сайжруулах | Сургалтанд хамрагдах | Сургалтанд идэвхтэй хамрагдах | Хууль , эрх зүйн орчинг судлах, мэдлэгээ сайжруулах | Аймгийн хууль зүйн хорооны гишүүдийг чадавхижуулах сургалтанд хамрагдсан. |

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

ӨСВӨР ҮЕИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ............................... / Ч.АДЪЯАСҮРЭН / 2025.06.25

*( АЛБАН ТУШААЛ )* *( НЭР, ГАРЫН ҮСЭГ )* *( ОГНОО )*

ТАЙЛАН ХЯНАСАН:

НЭМХ-ЫН ДАРГА ............................../Э.АРИУН-ЭРДЭНЭ/ 2025.07.08

*( АЛБАН ТУШААЛ )* *( НЭР, ГАРЫН ҮСЭГ )* *( ОГНОО )*